



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/19

Бат-Өлзий сум

Шууд худалдан авах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.1.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэг, Засгийн газрын “Худалдан авах ажиллагаанд баримтлах төсөвт өртгийн дээд хязгаар тогтоох тухай” 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоол, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “2024 оны төсөв батлах тухай” 2023 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 18/03 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх сирень дуут дохионы тоног төхөөрөмж худалдан авах ажлыг “Хөх морьт БМ групп” хязгаарлагдмал хариуцлагатай компаниар гүйцэтгүүлсүгэй.

2.“Хөх морьт БМ групп” хязгаарлагдмал хариуцлагатай компанитай гэрээ байгуулж, сирень дохионы тоног төхөөрөмж худалдан ажлын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасгай.

3.Гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх сирень дуут дохионы тоног төхөөрөмж худалдан авах зардалд шаардагдах 15,800,000 (арван таван сая найман зуун мянга) төгрөгийг гэрээний дагуу сумын эрсдэлээс хамгаалах сангийн зардлаас зарцуулахыг Төсвийн ерөнхий нягтлан бодогч (О.Отгонтуяа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН